



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 768

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 239,545,753.00 (Хоёр зуун гучин есөн сая таван зуун дөчин таван мянга долоон зуун тавин гурван төгрөг) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зармыг баримталж, шууд худалдан авалтыг бууруулах арга хэмжээ авч, худалдан авах ажиллагаанд хяналт тавьж ажиллах.

2.2. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3. “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (П.Баттулга)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, техник зохион байгуулалтын арга хэмжээ, их засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгийг худалдан авахгүй байх;

3.3. Эзэмших эрхийн газрын талбайн хэмжээнд өөрчлөлт орсон болон бүртгэлд тусгаагүй газрыг үнэлж санхүүгийн тайланд тусгах талаар санал боловсруулан, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

123007363

36-r_huraldaan.docx

3.4.Элэгдлээрээ анхны үнээ нөхсөн, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг тухай бүр, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

3.5.Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг үндэслэн компанийн мөнгөн кассын үйл ажиллагааны журам баталж ажиллах;

3.6.Худалдан авах ажиллагаанд Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

3.7.Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

3.8.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА		Б.ЦЭНГЭЛ
ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА		Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2023 оны 12 дугаар сарын 25-ны
өдрийн 768 дугаар тогтоолын хавсралт

**“БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ,
ДУТАГДАЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /төгрөг/	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Техникийн тодорхойлолт болон чадавхийн шаардлага хангаагүй хуулийн этгээдийг шалгаруулсан	239,545,753.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллах.
ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН		239,545,753.00	(Хоёр зуун гучин есөн сая таван зуун дөчин таван мянга долоон зуун тавин гурван төгрөг)